



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 09-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

## ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 - 17

---

- 1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/* 8 - 11
  - 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 11
  - 3. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/* 12
  - 4. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/* 13 - 17
-

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 09-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 48 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: Д.Өнөрболор;*

*Чөлөөтэй: Ц.Анандбазар, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Б.Чойжилсүрэн.*

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан төсвийн төслийг нягтлах шаардлага гарсан тул Төсвийн байнгын хорооны хуралдааныг түр хойшлуулж байгааг мэдэгдэв.

*Байнгын хорооны хуралдаан 09 цаг 51 минутад завсарлаж, 14 цаг 37 минутаас үргэлжлэв.*

***Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн гурав дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Г.Амартүвшин, С.Одонтуяа нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийг хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

---

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 8  
Бүгд: 14  
42.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ш.Раднаасэд нар санал хэлэв.

*“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан, Тогтоолын төслийн 7 дахь заалтад “Хавдар судлалын үндэсний төв 2 барилгын нэмэлт хөрөнгө оруулалтыг 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусган хэрэгжүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 8 дахь дэд заалтад “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих бүх шатын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний барилга, байгууламжийн жишиг зургийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэйгээр стандартад нийцүүлэн шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 34 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 08 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
09 цаг 48 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Ц.Даваасүрэн гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Ч.Хүрэлбаатар гишүүн, Ж.Батжаргал гишүүн, Ш.Раднаасэд гишүүн, Ж.Батсуурь гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүн, Б.Жавхлан гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Нийт 19 гишүүн хуралдаанд оролцохоос 12 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн

хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

**Нэг.**Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд. Гурав дахь хэлэлцүүлэг.

**Хоёр.**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Эцсийн хэлэлцүүлэг.

**Гурав.**“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

**Дөрөв.**Бусад гэсэн ийм асуудлууд байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Эхний асуудал. 2024 онд төсвийн тухай болоод 2024 онд Төсвийн тухай хуулийн төслүүдтэй холбогдуулж Байнгын хорооны зүгээс тодорхой төсвийн төслийн тоо, төслийг бас нягтлах магадлах зайлшгүй шаардлагатай байна.

Энэ үүднээс Төсвийн байнгын хорооны хуралдааныг түр хугацаагаар хойшлуулж байна. /алх цохив/



**Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,  
Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай,  
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай  
хуулийн төслүүд  
/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,  
гурав дахь хэлэлцүүлэг/**

Төсвийн байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлэв. Түрүүн хэлэлцэх асуудлыг танилцуулсан байгаа. 4 асуудалтай ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**Нэгдүгээр асуудал.**

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлэе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Сангийн сайд Б.Жавхлан. Б.Жавхлан сайдыг дуудаарай.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны төсвийн бодлого төл төрийн газар нь бол М.Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн

орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг гэсэн байна.

Нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусгах эцсийн хувилбарыг танилцуулгын хамтаар Та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөл болон танилцуулгатай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийх саналтай гишүүн байна уу?

Ш.Раднаасэд гишүүн байна.  
Ш.Раднаасэд гишүүн.

**Ш.Раднаасэд:** Хавдар эмнэлгийн 10 тэрбум гээд тавьчихсан. Тэрийг одоо эхлүүлэх гээд нэмье гэхээр болохгүй гээд байх юм.

Зарчмын өөрчлөлт орох гэж байна гээд. Ядаж **гурван цэг** тавьчихъя. Тэгэх үү? Ард талд нь. **Үргэлжилнэ шүү** гэсэн агуулгатайгаар. Тийм.

Тэр одоо **“эхлүүлэх”** гээд үг нэмэхэд юу нь болохгүй байна. Тэр чинь. Харин тийм. Бичиг өгөхөөр болохгүй гээд байх юм. Харин тийм.

**Г.Тэмүүлэн:** Ш.Раднаасэд гишүүн хуулийн 2 дугаар хавсралтын 149 дүгээр зүйл **“Хавдар судлалын үндэсний төв, 2 барилга”** гэсний дараа **“эхлүүлэх”** гэж нэмье гэсэн саналтай байгаа юм байна.

Энэ саналыг бас Ганибалын Амартүшин гишүүн бичгээр гаргаад, ажлын хэсэг болоод Байнгын хороонд ирүүлсэн байсан.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 71.1 дээр төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган, шаардлагатай бол гишүүнээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулгыг л зөвхөн хийж болно гээд заачихсан байгаа юм.

Тэгэхээр энэ нэг талдаа агуулгын өөрчлөлт гэж манай Байнгын хорооны зөвлөх болоод хуульч нарын зүгээс үзсэн. Тэгээд түүн дээр **“эхлүүлэх”** гэдэг саналыг нэмэх боломжгүй гэсэн хариуг өгсөн.

Тэгээд Их Хурлын дэгийн хуулиа баримтлаад явах өөр гарцгүй байгаа.

Г.Амартүшин гишүүн.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Миний харж байгаагаар нэг тодруулах тийм найруулгын шинж чанартай санал оруулсан юм л даа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2.2-ын төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх саналын 2.2.3 дугаар заалтад Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын **“орчны бохирдлыг бууруулах”** гэсний дараа **“бусдаар гүйцэтгүүлэх”** гэж нэмэх гэж оруулсан юм.

Энэ ямар учиртай юм бэ гэхээр Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо татан буугдаад **25.8** тэрбум төгрөгийн төсөв нь Эрчим хүчний сайдын багцаас хасагдаад Байгаль орчны сайдад нэмэгдэж байгаа юм.

Тэгээд гол нь нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдол, хөрсний бохирдлыг бууруулахтай холбоотой үйл ажиллагааг хот хариуцах тул үүнийг ингээд **“бусдаар гүйцэтгүүлэх”** тодотголд оруулах, илүү тодорхой болгох тийм санал оруулсан юм л даа.

Яагаад гэвэл төсөв нь яамны багцад байна. Яг ажлыг гүйцэтгэх нь нийслэл болчихоод байгаа болохоор энэ дээр яах вэ, болгоомжлоод 2024 онд нийслэл нь хариуцлагыг нь хүлээгээд байдаг. Гэтэл төсөв нь гарахгүй байвал яах вэ л гэсэн тийм л асуудал байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Г.Амартүшин гишүүнд баярлалаа.

Тэгэхээр Төсвийн тухай хуулийн төсөлд энэ тусгуулах санал дээр Г.Амартүшин гишүүн хуулийн төслийн 2.2 буюу төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх саналын 2.2.3 дугаар заалтад Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын орчны бохирдлыг бууруулах гэсний дараа бусдаар гүйцэтгүүлэх гэж нэмэх гэсэн ийм саналыг өгөөд байгаа.

Тэгэхээр 2.2 гэдэг маань өөрөө төсвийн урсгал зардалтай холбоотой асуудал. Манай дэгээр болохоор 71.1-д заасны дагуу зөвхөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн өөрчлөхгүй, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр гэж байгаа юм.

Тэгэхээр хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд дээр л “залруулга” гэдэг юм уу, “нэр, хүчин чадал, байршилтай холбоотой” л залруулга хийх боломж бололцоо байгаа гэсэн үг болчхож байгаа юм. Редакцын засвар.

Тэгэхээр саяын “урсгал зардал” гэдэг асуудал маань гуравдугаар хэлэлцүүлэг дээр Байнгын хороон дээр болоод Улсын Их Хурал дээр ямар нэгэн өөрчлөлт оруулах боломж бололцоо хуулийнхаа хүрээнд дэгийн хуулиараа байхгүй болчихоод байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Г.Амартүшин гишүүн нэмж санал хэлье.

**Г.Амартүшин:** Би тайлбарыг ойлголоо.

Тэгээд үүнтэй холбоотой зүгээр протоколд тэмдэглүүлмээр байна л даа.

Энэ дээр **дефакто** ийм ойлголттой бид үүнийг баталж байгаа шүү.

Өөрөөр хэлбэл төсөв нь болохоор Байгаль орчны яамны төсөвт байна.

Гэхдээ **дефакто** үүнийг нийслэл бүх ажлыг хийнэ шүү гэдэг л тийм ойлголттой баталж байна гэж би тэмдэглэмээр байгаа шүү. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо Г.Амартүшин гишүүн санал хэлээд, протоколд саяынхаа хэлсэн саналаа тусгууллаа.

Х.Баделхан гишүүн тодруулах зүйл байсан уу? Ойлголоо.

Тэгвэл өөр санал гаргах гишүүд байхгүй юм байна. Тэгээд зарчмын зөрүүтэй санал гарвал санал хураах байсан.

С.Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга “урсгал зардал” гээд Байнгын хороон дээр ерөөсөө хасагдаагүй гээд явж байсан юм.

Тэгсэн чинь энэ дээр ингээд дүн нь дарагдаад ороод ирсэн байх юм. 160-аар зөрчихсөн.

Энэ хаана, хэзээ, хэн мэдээд хасчихсан юм бол оо?

**Г.Тэмүүлэн:** С.Одонтуяа гишүүний асуултад Сангийн яам хариулах уу? Сангийн яамны М.Санжаадорж хариулах уу? Хөрөнгө оруулалтын. 5 номер.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. С.Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Хоёрдугаар хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй “бууруулах санал” дээр бол бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүх шатны төсвөөс 1.88 хувиар бууруулах санал гарч дэмжигдсэн байгаа.

Энэ хүрээндээ урсгал зардал нь тооцогдоод тэгээд буурсан байна.

Ер нь зүгээр Цагаатгах ажлын комиссын хувьд үйл ажиллагааны зардал маш бага. Жаахан төсөв эзэлдэг. Нөгөө талдаа нөгөө нөхөн олговрын зардал нэлээд дийлэнх эзэлдэг.

Тийм учраас 160 гээд том юм шиг тоо харагдаж байгаа байх. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгал сангийн 2024 он төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн дарга Д.Тогтохсүрэн гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Тэгээд Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

---

**Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл,  
2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төсөл**

*/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,  
эцсийн хэлэлцүүлэг/*

---

**Хоёр дахь асуудал.**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлбэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүн танилцуулснаар байгаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болоод хуулийн төслийг Та бүхэнд

танилцуулгыг нь бэлтгэж тараасан байгаа.

Ингээд эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн дарга Д.Тогтохсүрэн гишүүн танилцуулна.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

**Гурав. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”**  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл  
*/анхны хэлэлцүүлэг/*

**Гурав.** “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар хийх үед төсвийн тооцоололтой холбоотойгоор шаардлагатай бол хууль тогтоолын төслийг боловсруулах санал дэмжигдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хуулийн 44.5-д заасныг үндэслээд “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлаад боловсруулсан.

Та бүхэнд Төсвийн байнгын хорооноос боловсруулсан тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асууж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгээр нь эцсийн хэлэлцүүлгийг хамтад нь хэлэлцэн батлах горимын саналыг гаргаж байна.

Санал хураалт бүхэнд явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Ш.Раднаасэд гишүүн горимын санал гаргах гэж байна уу? Тийм ээ.

**Ш.Раднаасэд:** Тэр хавдрын эмнэлэг чинь. За за. Тоног төхөөрөмж ажилласангүй. Дахиж санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Ш.Раднаасэд гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

64.3 хувиар дэмжигдлээ.

Саяын санал хураалт дэмжигдсэн тул өмнөх санал хураалт хүчингүй болж ингээд зарчмын зөрүүтэй санал гараагүй учир төслийг анхны хэлэлцүүлгээр батлуулах горимын саналын талаар дэмжье гэдгээр санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Анхааралтай байгаарай гишүүд.

64.3 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

**Дөрөв. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай  
хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авах  
зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл  
/анхны хэлэлцүүлэг/**

**Дөрөв дэх асуудал.** Бусад гэсэн асуудал дээр байгаа.

Д.Тогтохсүрэн гишүүн Та санал гаргаад саналаа танилцуулаад явах уу?

Д.Тогтохсүрэн гишүүнд микрофоныг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Уржигдар Байнгын хороогоор дагасан хуулиудын эцсийн хэлэлцүүлэг явагдсан.

Энэ үед дагасан хуулиудыг дагаж гарч байгаа тогтоолтой холбогдуулсан асуудлын эцсийн хэлэлцүүлэг хийчихсэн юм.

Ингээд эцсийн хэлэлцүүлэг. Манай гишүүд сайн мэдэж байгаа.

Эцсийн хэлэлцүүлэг хийгдээд төгсгөлийн шатад ороод дууссаны дараа Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайд манай Сангийн сайд нараас заавал дагаж гарах тогтоол дээр тусгах шаардлагатай хэдэн асуудал **боловсрол, эрүүл мэндийн асуудал** үлдчихлээ гэсэн юм.

Тэгээд энэ нь үлдчихсэн юм. Тэгээд үүнтэй холбогдуулаад Байнгын хороо ажлын хэсэг ярилцаад Байнгын хороо бүрэн эрхийнхээ дагуу хуулийн төслийг батлагдсантай холбогдуулж

гарах тогтоолын төслөө боловсруулсан юм.

Энэ нь зөвхөн **эрүүл мэнд, боловсрол хоёртой холбоотой** зохион байгуулалтын шинэчлэлийн хэдэн асуудал нь үлдчихсэн юм.

Тэгээд би уншчихъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол гээд.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1/Боловсрол дахь тэгш бус байдлыг арилгах, боловсролын чанарыг сайжруулах, хүртээмжийг нь нэмэгдүүлэх, боловсролын цахим шилжилтийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн анги, танхимыг интернэт, дотоод сүлжээнд бүрэн холбох, багш бүрийг компьютержуулах, хүүхдийн авьяасыг дэмжих цахим системд суурилсан нэмэлт хөтөлбөрүүдийг

хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулах гэдэг нэг ийм санал байгаа юм.

Хоёр дахь нь. Нийслэл, орон нутагт гурван ээлжээр хичээллэж байгаа сургуулиудын хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалтад хяналт тавьж, цаашид боловсролын хүртээмжийг дээшлүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах.

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулийн хэрэгжилтийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол тэгш хамралтыг нэмэгдүүлэх, тэдний цогц хөгжлийг дэмжих, салбар дундын зохицуулалтыг сайжруулах чиглэлээр төсвийн санхүүжилтийг жил бүр нэмэгдүүлэхэд холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, тэгш эрхийг хангах зорилгоор сургалтын орчинг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлж хувийн хэвшилтэй хамтран ажиллах.

5.Сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, ажилчдад зарцуулагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх гэсэн боловсруулалттай ийм таван заалт байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ төсөвтэй холбоотой дагаад л Боловсролын сайдад улсын хэмжээнд авч хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал байгаа юм.

6.Эрүүл мэнд дээр. Монгол Улсын засаг захиргаа, хамтлагийн төсвийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.16 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах гээд.

Энэ нь эрүүл мэндийн тогтмол зардал нь орон нутаг руу яваагүй байсан юм билээ. Үүнтэй холбоотой асуудал байгаа.

Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо Г.Тэмүүлэнд даалгасугай.

Энэ тогтоолыг 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм Эрүүл мэнд, Боловсрол, Сангийн сайд нарын ярилцсаны дагуу зөвхөн эрүүл мэнд, боловсролтой холбоотой асуудлаар нь ийм тогтоол гаргах шаардлага үүсчихсэн байна.

Түрүүний явсан тогтоолд орохоор тэр нь эцсийн хэлэлцүүлэг хийгдчихсэн учраас орох ямар ч боломжгүй болчихсон юм.

Тийм учраас зөвхөн энэ хоёртоо зориулж ийм тогтоол гаргах шаардлага үүссэн юм гэдгийг Та бүхэнд хэлье. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Бусад гэсэн асуудлын хүрээнд сая ажлын хэсгээс оруулж ирж байгаа тогтоолын төслийг Д.Тогтохсүрэн даргад танилцууллаа.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараачихсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Кнопоо дараарай. Х.Булгантуяа, Ш.Раднаасэд гишүүд.

Х.Булгантуяа гишүүн асуулт асууя.

**Х.Булгантуяа:** Тогтоолын төслийг дэмжиж байна.

Үүн дээр нэг ганц зүйл, заалт оруулчихмаар байна. Г.Тэмүүлэн дарга аа,

Ерөнхий сайд, сая бид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвүүдийг аймаг, орон нутагт нээлт хийгээд явж байхад ялангуяа манай сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгууд маань хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд их ээлгүй барилга баригдаад байгаа юм.

Тэгэхээр бид энэ жишиг зургийг шинэчлээд, ялангуяа улсын төсвөөс баригдаж байгаа сургууль, цэцэрлэгүүд, эмнэлгийн барилгуудыг мөн адилхан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгох жишиг зургийг шинэчлэх ажлыг бид ирэх жил хийгээд.

Тэгээд 2025 оноос шинээр баригдах сургууль, цэцэрлэгүүдийг эхнээс нь ээлтэй болгох энэ ажлыг хийх үүрэг чиглэлийг бас давхар өгчхөөч ээ. Зураг төсвийн зардал нь Ч.Хүрэлбаатар сайдын багц дээр угаасаа явдаг.

Тэгэхдээ сургууль, цэцэрлэгийн гэдгээрээ эрүүл мэндийн барилгууд ерөнхийдөө болно гэсэн үг. Тийм. Энэ шууд 2024 оны төсөв дээр ачаалал өгөхгүй. Би саналын томъёоллыг нь бэлдээд танд хүргүүлчихье. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нөгөө Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Үндэсний зөвлөлөөс өгсөн саналын хувьд яасан бол? Г.Тэмүүлэн дарга аа.

Тэрийг ипотекийн юун дээр ямар нэгэн байдлаар зохицуулалт хийж суулгаж болохгүй юу?

**Г.Тэмүүлэн:** Х.Булгантуяа гишүүн зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргах юм байна. Та саналын томъёоллоо бэлдэж байгаарай.

Саяын асуусан сүүлийн асуулт дээр Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр хоёрдугаар хэлэлцүүлгийг хэлэлцэх үед хурал даргалагчаас ямар нэгэн энэ асуудлаар чиглэл өгөгдөөгүй байгаа.

Тэгэхээр энэ дээр бид өөрчлөлт оруулах буюу залруулга хийх ямар нэг боломж бололцоо байхгүй.

Ш.Раднаасэд гишүүн.

**Ш.Раднаасэд:** Энэ одоо ингэнэ. Түрүүн “эхлүүлэх” гээд тавья гэхээр тавьж болохгүй гээд байна шүү дээ. Хавдрын эмнэлэг дээр. Харин тийм.

Тэгэхээр энэ дээр оруулж өгөхгүй бол. Одоо наадах чинь худалдан авах ажиллагаа байгаа 10 тэрбумд нь зарлаад л тэгээд зарцуулаад л дуусна гэж байна. Төсөвт өртөг нь хэзээ яаж гарах вэ, дуусах вэ гээд.

Тэгэхээр энэ дотор байна шүү дээ. Энэ хавдрын эмнэлэг 2 төслийн үргэлжлэл нэмэлт хөрөнгө оруулалтыг 2025 оны төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээг Эрүүл мэндийн сайдад даалгасан байдалтайгаар нэг юм үлдээхгүй бол одоо энэ чинь ингээд 2024 он, 2025 оны



төсвийг шинэ Их Хурал хийнэ. Үүнийг ерөөсөө огт тоох ч үгүй. Тэгээд л хаяад явна.

Тэгээд ядаж нэг ийм эрх зүйн үндэс үлдээж орхихгүй бол тэнд нэг 10

**Г.Тэмүүлэн:** Ш.Раднаасэд гишүүн та саналын томьёоллоо бэлтгээрэй.

Ингээд хоёр саналын томьёолол хоёр гишүүнээс гарч байгаа юм байна. Хоёр зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураагаад тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дуусах юм байна. Гишүүд саналаа шуурхайлаарай.

Ш.Раднаасэд гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Тогтоолын төслийн 7 дахь заалт. Саналын томьёолол.

Хавдар судлалын үндэсний төв 2 барилгын нэмэлт хөрөнгө оруулалтыг 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусган хэрэгжүүлэх гэсэн байна.

Ийм саналын томьёолол бичгээр ирүүлсэн байна.

Ш.Раднаасэд гишүүний гаргасан саналыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

64.3 хувиар дэмжигдлээ.

Одоо Х.Булгантуяа гишүүний гаргах саналын томьёолол байгаа.

Саналын томьёоллыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

тэрбум газар булдаг юм уу, яадаг юм, эсвэл нэг шугам татдаг юм уу тэгээд тэр мартагдаад алга болно.

Тэгэхээр энэ дээр нэг заалт оруулаад хийгээд явчих нь зөв байх.

Тогтоолын төслийн 8 дахь дэд заалт дээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих бүх шатын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний барилга байгууламжийн жишиг зургийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэйгээр стандартад нийцүүлэн шинэчлэн баталж хэрэгжилтийг хангах гэсэн ийм заалт орж ирж байгаа юм байна.

Ийм томьёоллоор Х.Булгантуяа гишүүн санал гаргасан байна.

Х.Булгантуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Г.Амартүшин гишүүн дэмжсэнээр орж байгаа юм байна.

Ингээд 57.1 хувиар дэмжигдсэн байгаа. Нэмэх нь Г.Амартүшин гишүүн байгаа юм байна. Ингээд энэ саналын томьёолол дэмжигдлээ.

Өөр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байхгүй байна.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нэгдсэн хуралдаанд танилцуулчих уу? Х.Булгантуяа гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа Та бүхэнд.

*Хуралдаан 34 минут үргэлжилж, 15 цаг 08 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**

